

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2024 оны 12 сарын 31 өдөр

Дугаар: 25

Улаанбаатар хот

**Ногдол ашиг хуваарилах
тухай**

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 76 дугаар зүйлийн 76.1.12, 76.1.18, 80 дугаар зүйлийн 80.2, Даатгалын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.9, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 351 дүгээр тогтоол, Хувьцаа эзэмшигч (Сангийн сайд)-ийн 2024 оны 01/10864 дүгээр албан бичиг, Сангийн сайдын 2017 оны 1 дүгээр тушаалаар батлагдсан “Үндэсний давхар даатгал” ХК-ийн дүрмийн 4.2.3, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 3.3.18-д заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Үндэсний давхар даатгал” ХК-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийн цэвэр ашгийн дүнгээс 5,500,000,000 (таван тэрбум таван зуун сая) төгрөгийн ногдол ашиг хуваарилсугай.

2. Хуваарилсан ногдол ашгаас 410,855,300 (дөрвөн зуун арван сая найман зуун тавин таван мянга гурван зуун) төгрөгийг татварт тооцож, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 7 дугаар сарын 04-ний өдрийн 351 дүгээр тогтоолыг үндэслэн төрийн өмчийн хувьцаанд ногдох 1,391,447,000 (нэг тэрбум гурван зуун ерэн нэгэн сая дөрвөн зуун дөчин долоон мянган) төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх, 3,697,697,700 (гурван тэрбум зургаан зуун ерэн долоон сая зургаан зуун ерэн долоон мянга долоон зуун) төгрөгөөр “Үндэсний давхар даатгал” ХК-ийн МИД-ын нөхөн төлбөрийн нөөц сангийн хөрөнгийг нэмэгдүүлэхийг Гүйцэтгэх захирал (Б.Жавхлант)-д тус тус үүрэг болгосугай.

3. Төрийн өмчийн хувьцаанд ногдох ногдол ашгийг Сангийн яамны Төрийн сангийн улсын төсвийн орлогын ногдол ашгийн 100900000702 тоот дансанд 2024 оны 4 дүгээр улиралд багтаан төвлөрүүлж, гүйцэтгэлийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал (Б.Жавхлант)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоолыг Хувьцаа эзэмшигч (Сангийн сайд)-д танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Ч.Тавинжил)-д, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо (Ц.Дашдондог)-нд тус тус даалгасугай.

ДАРГА



Ч.ТАВИНЖИЛ